



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 12 сарын 26 өдөр


Дугаар 1/605

Улаанбаатар хот

Г Аргачлал, норматив хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3, 8.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлалыг нэгдүгээр хавсралтаар, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын норматив хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү аргачлалыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд “Эрүүл мэндийн аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс”-ийг батлагдсан төсөвтөө багтааж шийдвэрлэхийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т тус тус даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 459 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.



082323

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
12..сарын 26-ны өдрийн дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү тушаалын зорилго нь эрүүл мэндийн байгууллагаас үүсэх аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлсийг тогтоосноор хог хаягдлын менежментийг сайжруулах, эрсдэлийг бууруулах, төсвийг тооцох, төсвийн хуваарилалтыг сайжруулж, улмаар эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын хэмжээг бууруулахад чиглэгдэнэ.

1.2. Хог хаягдлын тухай хуулийн 41.4-т заасны дагуу гэрээний үндсэн дээр төлбөрийн хэмжээг энэ тушаалын хоёрдугаар хавсралтанд заасан норматив хэмжээг үндэслэн гэрээгээр тохирч төлнө.

1.3. Хог хаягдлыг тээвэрлэх, боловсруулах, устгах төвлөрсөн байгууламжгүй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллага нь энэхүү үйл ажиллагааны зардлыг өөрийн байгууллагын төсөвт тусгаж шийдвэрлэх бөгөөд тус үйл ажиллагааны хэрэгжилтэд Хог хаягдлын тухай хуулиар эрх бүхий этгээд хяналт тавина.

1.4. Энэхүү аргачлал, норматив нь эрүүл мэндийн байгууллагын энгийн хог хаягдалд хамаарахгүй.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягал” гэж эрүүл мэндийн байгууллагаас үүсэх халдвартай, хурц үзүүртэй, иртэй, эмгэг, эмийн болон эсэд хортой нөлөөтэй, химийн бодисын болон цацраг идэвхит хог хаягдлыг;

2.2. “Үйлчилгээний хөлсийг тооцох аргачлал” гэж эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийн үйлчилгээний хөлсийг тооцоход мөрдөх баримт бичгийг;

2.3. “Төлбөр” гэж эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментэд төлөх үйлчилгээний хөлсийг;

2.4. “Тээвэрлэх үйлчилгээний хөлс” гэж эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын түр хадгалах байрнаас эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламж хүртэл зайнд тээвэрлэх зардлыг;

2.5. “Устгах үйлчилгээний хөлс” гэж эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зориулалтын зууханд шатаах болон стандартын дагуу халдвартгүйжүүлж, ландфилл хийх үйл ажиллагааны зардлыг;

2.6 “Норматив хэмжээ” гэж эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын төрлөөс хамаарч нэг ор хоногт болон нэг үзлэгт ногдох хэмжээг хэлнэ.

#### **Гурав. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын төлбөрийг тооцох**

3.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлсийг доорх томъёогоор тооцно.

$$T = O + I$$

T – Эрүүл мэндийн байгууллагаас нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын нийт төлбөрийн хэмжээ

O – Амбулаторийн үзлэгээс нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ

I – Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ

$$O = TV * N_o * C_o$$

O – Амбулаторийн үзлэгээс нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ

TV – Тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн амбулаторийн үзлэгийн тоо хэмжээ /лаборатори, оношилгоо бүрийг нэг амбулаторийн үзлэг гэж үзнэ/

N<sub>o</sub> – Амбулаторийн нэг үзлэгт ногдох аюултай хог хаягдлын норматив хэмжээ /Тушаалын хоёрдугаар хавсралт/

C<sub>o</sub> – Амбулаторийн нэг үзлэгт ногдох аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээг гэрээгээр тохирсон тарифын хэмжээ

$$I = BD * N_i * C_i$$

I – Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ

BD – Тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн амбулаторийн үзлэгийн тоо хэмжээ /лаборатори, оношилгоо бүрийг нэг амбулаторийн үзлэг гэж үзнэ/

**N<sub>i</sub>** – Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг ор хоногт ногдох аюултай хог хаягдлын норматив хэмжээ /Тушаалын хоёрдугаар хавсралт/

**C<sub>i</sub>** – Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг ор хоногт ногдох аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээг гэрээгээр тохирсон тарифын хэмжээ

3.2. Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллага нь энэ тушаалын 3.1-т заасан аргачлалын дагуу хог хаягдлын зардлыг тооцож, жил бүрийн төсөвт тусгаж батлуулж, батлагдсан төсөвтөө багтааж хэрэгжүүлнэ.

3.3. Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 41.4-т заасан үйлчилгээг бусдаар гүйцэтгүүлэх гэрээг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

3.4. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь энэ тушаалын 3.1-т заасан аргачлалын дагуу аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах зардлыг өөрийн төсөвтөө тусгаж мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
26.-ны өдрийн дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН  
НОРМАТИВ ХЭМЖЭЭ

№	Аюултай хог хаягдлын төрөл	Нэг ор хоногт ногдох /грамм/	Нэг үзлэгт ногдох /грамм/
1.	Халдвартай	127	67.7
2.	Хурц үзүүртэй, иртэй	30.3	13.6
3.	Эмгэг	1.9	0.3
4.	Эмийн болон эсэд хортой нөлөөтэй	6.8	0.5
5.	Химиин бодис	0.2	4.7
6.	Цацраг идэвхит	1.6	0.5

Эх сурвалж: ЭМЯ, АХБ-ны Эрүүл мэндийн  
салбарын хөгжил, хөтөлбөр -5 төслийн  
Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын  
төгсгөлийн үнэлгээний үр дүн -2019.